



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/408

Булган сум

“Сансар марафон 2025” гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хүн сансарт ниссэний 44 жилийн ойг тохиолдуулан гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор “Сансар марафон 2025” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:


Ажлын хэсгийн дарга: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)
Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, Хурандаа)
Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
В.Батболд (Аймгийн Хөнгөн атлетикийн холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010571